



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/370

Улаанбаатар хот

Жагсаалт, журам шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 226 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт”-ыг нэгдүгээр, “Гадаад оронд зайлшгүй эмчлүүлэх шаардлагатай иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар, “Гадаад оронд зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-ыг гуравдугаар, “Гадаад оронд зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд эмнэлгийн дүгнэлт гаргах маягт”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчин, эмгэгийн улмаас гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчилгээ хийлгэх иргэдэд дүгнэлт гаргах орон тооны бус комисс байгуулж, үйл ажиллагааг нь удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Улсын нэг, хоёр, гуравдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалтаас хасагдсан эмчилгээ болон цаашид багасгахад чиглэсэн шаардлагатай тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, эрүүл мэндийн даатгалаас хөнгөлөлтөд хамруулах, хүний нөөцийг бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Бодлого төлөвлөлтийн газар /Д.Төмөртоого/, Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Л.Мөнхтулга/, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

081196

5. Тушаал шинэчлэн батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны “Жагсаалт, журам батлах тухай” 313 дугаар, 2015 оны “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 119 дүгээр тушаал, 2016 оны А/195 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын “Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах зөвлөлийн бүрэлдэхүүн” хэсгийг тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

6. Энэхүү тушаалыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 09 сарын 21 -ны өдрийн
А/370 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**МОНГОЛ УЛСАД ЭМЧЛЭХ БОЛОМЖГҮЙ
ӨВЧНИЙ ЖАГСААЛТ**

№	Өвчний нэр, эмчилгээний төрөл		
	Монголоор	Оросоор	Англиар
A.	Мэдрэлийн мэс засал	Нейрохирургия	Neurosurgery
1.	Тархи, нугасны гүний, төвөгтэй байрлалтай, мэс заслаар авах боломжгүй болон бусад ажилбар, эмчилгээ шаардагдах хавдар, хавдар төст эмгэгийн мэс засал эмчилгээ	Неоперабельные опухоль и опухольподобные болезни глубинной локализации головного и спинного мозга но требующие другие варианты вмешательства и лечения	Inoperable tumors and tumor-like disease
2.	Паркинсоны өвчин, торсион дистонид стереотакс мэс заслын аргаар тархины гүний өдөөлт (deep brain stimulation) хийн, электрод суулгах эмчилгээ	Стереотаксические вмешательства такие как глубокая мозговая стимуляция и имплантация электрода при болезни Паркинсона и торсионной дистонии	Stereotactic procedures such as deep brain stimulation and implantation of electrical stimulators in Parkinson's disease and torsion dystonia
B.	Чих хамар хоолой	Отоларингология	Otorhinolaryngology
3.	Сонсголын мэдрэлийн хавдрын үеийн мэс засал	Опухоль слухового нерва	Acoustic neuroma-Surgery from Acoustic neuroma
4.	Вегенерийн өвчний хүнд хэлбэр үеийн эмчилгээ	Тяжелая форма болезни Вегенера	Severe form of the Vegeners disease
5.	Меньерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн мэс засал	Тяжелая форма болезни Меньера	Severe form of the Menieris diseases-Saccotomy for Meniere's disease
B.	Нүд судлал	Офтальмология	Ophthalmology
6.	Дутуу нярайн торлогийн эмгэгийн улмаас торлог ховхрох үеийн торлог шилэнцрийн мэс засал	Тракционная отслойка сетчатки ретинопатии недоношенных	Tractional Retinal Detachment of Retinopathy of Prematurity

Г.	Зүрх, судасны мэс засал	Кардиоваскулярная хирургия	Cardiovascular surgery
7.	Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал, судасны дисплази эмчилгээ	Тяжелая степень сужения коронарного сосуда сердца	Severe form of the coronary artery stenosis
8.	Хүүхдийн хавсарсан хөх, хүнд хэлбэрийн гажигийн үеийн мэс засал эмчилгээ	Тяжелые синие врожденные аномалии сердечной перегородки	Severe form of Congenital malformations of cardiac septa
9.	Зүрхний том судаснуудын гаж байрлалын мэс засал эмчилгээ	Транспозиция больших сосудов сердца	Transposition of the heart great vessels
10.	Гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн, хуулралын эмчилгээ	Тяжелая форма аневризма аорты	Severe forms of the aortic aneurism
11	Зүрхний хавхлагуудын өөрчлөлт болон ишеми өвчний улмаас агших чадвар 25 хувиас доош болсон тохиолдлын эмчилгээ	Лечение при снижений сердечного выброса на 25% и ниже вследствие сердечных клапанных изменений и ишемической болезни сердца	Intra-aortic Balloon Counterpulsation IABC, Extracorporeal Membrane Oxygenation ECMO
Д.	Хавдар	Онкология	Oncology
12	Толгой хүзүүний өргөтгөсөн мэс заслын дараах согог, эрхтнийг хиймэл эрхтэн буюу протезоор орлуулах (хиймэл төвөнх), нармайн хавдрын мэс засал эмчилгээ	Протезирование после расширенных операций головы и шей, искусственная гортань и операций при злокачественных опухолях носоглотки	Larynx prosthesis, prosthesis of functional deficit and anatomical defect after extended surgery head and neck cancers, Surgical treatment of nasopharyngeal cancer
13.	Цагаан мөгөөрсөн хоолойн хавдрын эмчилгээ	Хирургическое лечение рака трахеи	Surgical treatment for cancer of the trachea
14.	Яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс засал - Мөч хадгалах боломжтой үеийн хорт хавдар - Бага аарцаг, цээжний хананы байрлалтай хорт хавдар	Реконструктивные операции мягких тканей и костей - Органосохраняющие операции на конечностях - Злокачественные опухоли грудной клетки и малого таза	Reconstruction Surgery of the Soft and Bone Tumors - Limb-sparing resection in the extremities and larynx - Malignant tumors of pelvis and chest wall -

15.	Тархи хавдрууд, хүзүүний хавдрын стереотактик эмчилгээ	нугасны толгой дахисан үеийн туяа	Стереотактическая лучевая терапия для опухоли головного и спинного мозга и для рецидивирующих опухолей головы и шей	Stereotactic radiotherapy for brain and spinal cord tumors and for recurrent head and neck tumors
Е.	Уушги судлал		Пульмонология	Pulmonologia
16.	Уушгины гажгийн эмчилгээ	төрмөл мэс засал	Врожденная патология легких	Congenital disorders of lungs
Ё.	Гэмтэл судлал	согог	Травматология и ортопедия	Traumatology and orthopedics
17.	Дээд мөчдийн хүнд хөгжил, гэмтэл	болон доод төрөлхийн дутуу	Врожденная верхняя и конечностей	Severe form of Congenital Amelia or hemimelia of limbs.
18.	Хүзүү тасарсан хүнд үеийн мэс засал	нурууны гэмтлийн	Хирургическое лечение неврологические повреждения позвоночника и спинного мозга	Disorders of the sub'axial cervical spine Klippel- Feil syndrome
19.	Сээр, нурууны муруйлт мэс засал	бүсэлхий төрөлхийн эмгэгийн	Врожденный грудного и отдела позвоночника	Disorders of the thoracolumbar spine scoliosis
Ж.	Эрхтэн шилжүүлэн суулгах		Общая хирургия	General surgery
20.	Донороос реципентэд чөмөг шилжүүлэн суулгах	ясны шилжүүлэн	Трансплантация костного мозга	Bone marrow transplantation
21.	Зүрх, булчирхай, уушги суулгах	нойр гэдэс, шилжүүлэн	Трансплантация поджелудочной кишки и лёгких	Heart, pancreas, bowel and lung transplantation
22.	Элэгний идэвхижил болон реципентэд бөөр суулгах	вирусын өндөр өмөнтэй элэг, шилжүүлэн	Трансплантация почки и печени при высокой степени активности вирусного гепатита и злокачественной опухоли	Kidney and liver transplantation for recipients with a high viral activation and cancer
23.	Тунгалагийн гаж сэргээх /Зааны өөрчлөлт/	судасны нөхөн мэс засал	Реконструктивно-пластические операции при лимфедеме	Elephantiasis /lymphedema/ reconstructive surgery
З.	Эх эмэгтэйчүүд, үргүйдэл судлал	барих	Акушерство, гинекология, бесплодия	Obstetrics' and gynecology and infertility
24.	Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтний гаж		Пластическая Врожденной операции аномалии	Complete Mayer – Rokitansky-Kustner-

	хөгжлийн үе дэх нөхөн сэргээх мэс засал	развития влагалища	Hauser Syndrome: Vaginal re-constructive surgery
25.	Ихэр жирэмсний үед ургаас урагт цус юүлэгдэх хам шинжийн үеийн лазер эмчилгээ	Внутриматочная лазерная абляция сосудистых анастомозов при фето-фетального трансфузионного синдрома	Intrauterine laser ablation of placental vessels for the treatment of twin-to-twin transfusion syndrome
26	Үр хөврөлийг умайд суулгахаас өмнө генетикийн оношилгоо	Преимплантационная генетическая диагностика	Preimplantation Genetic Diagnosis (PGD)

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 09 сарын 27-ны өдрийн
А/370 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



**ГАДААД ОРОНД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР ЭМЧЛҮҮЛЭХ
ИРГЭДЭД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АСУУДЛААР
САНАЛ ГАРГАХ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн дарга: дарга	Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн
Дэд дарга:	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга
Гадаад эмчилгээний урсгал хариуцсан нарийн бичиг:	Эрүүл мэндийн яамны мэргэшсэн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
Гадаад эмчилгээний санхүүжилтийн тооцоолол хариуцсан нарийн бичиг:	Эрүүл мэндийн яамны ахлах нягтлан бодогч
Гишүүд:	Эрүүл мэндийн яамны Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга
	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал
	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал
	Улсын гуравдугаар төв эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал
	Хавдар судлалын үндэсний төвийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал
	Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал
	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 09 сарын 21 ны өдрийн
А/320 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



**ГАДААД ОРОНД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР ЭМЧЛҮҮЛЭХ
ИРГЭДЭД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АСУУДЛААР
САНАЛ ГАРГАХ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН
АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журам нь Эрүүл мэндийн сайдын дэргэдэх гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлсэн Монгол улсын иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн (цаашид “Зөвлөл” гэх) үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Зөвлөлийн ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хурал байна. Зөвлөлийн хурлыг гишүүдийн 75 хувиас дээш ирцийг бүрдүүлсэн тохиолдолд хүчинтэйд тооцох ба зөвлөлийн гишүүд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд ирэх боломжгүй тохиолдолд тухайн гишүүний ажил, үүргийг орлон гүйцэтгэж байгаа албан тушаалтан хуралд оролцоно.

1.3. Зөвлөл нь Улсын нэг, хоёр, гуравдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн гадаад эмчилгээний комиссын дүгнэлттэй, холбогдох материалыг бүрдүүлж ирүүлсэн иргэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг зөвлөлдөн нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

1.4. Зөвлөл нь 2 сар тутамд 1 удаа хуралдана. Шаардлагатай үед зөвлөлийн даргын шийдвэрээр хурлыг зарлан хуралдуулж болно. Хурлыг зөвлөлийн дарга, түүний эзгүйд болон зөвшөөрлөөр дэд дарга даргалж болно.

1.5. Зөвлөл нь хуралдааны талаар хурлын тэмдэглэл хөтөлж, олонхийн саналаар шийдвэрлэсэн асуудлыг Эрүүл мэндийн сайдад танилцуулж шийдвэр гаргуулна. Тэмдэглэлийг гадаад эмчилгээний урсгал хариуцсан нарийн бичгийн дарга хөтөлж, зөвлөлийн дарга, дэд дарга нар хянаж гарын үсэг зурж баталгаажуулна.

1.6. Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалт, зөвлөлийн ажиллах журам, санхүүгийн дэмжлэг хүсэхэд бүрдүүлэх материал болон бусад тайлбар мэдээллийг Эрүүл мэндийн яамны веб хуудсанд ил байршуулна.

Хоёр. Зөвлөлийн үүрэг

2.1. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь хууль дээдлэх, шударга ёс, хариуцлага хүлээх зарчмын хүрээнд хуралдаанаар хэлэлцэгдэх асуудлыг зөвлөлдөн, хууль

тогтоомжид нийцсэн нэгдсэн шийдвэр санал гаргаж, Эрүүл мэндийн сайдад дэмжлэг үзүүлнэ;

2.2. Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Санхүүжилт олгох журам"-ын дагуу шаардлага хангасан материалыг өрхийн эмчийн тодорхойлолтын хамт бүрдүүлсэн иргэний асуудлыг хэлэлцнэ;

2.3. Зөвлөлийн бүрэлдэхүүн нь төрийн алба хаагчийн болон эмчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүйгээр хурлаар хэлэлцүүлж байгаа дэмжлэг хүссэн иргэн бүрээр нарийвчлан хэлэлцэн шийдвэрлэн;

2.4. Зөвлөлийн дарга нь гадаад эмчилгээний зардлын зарцуулалтын тайланг хагас жил тутам Эрүүл мэндийн сайдын зөвлөлд танилцуулна;

2.5. Зөвлөлийн гадаад эмчилгээний урсгал хариуцсан нарийн бичиг:

2.5.1. "Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалт"-д ороогүй өвчин, эмгэгтэй иргэн гадаад улсад эмчилгээний зардал хүссэн тохиолдолд уг иргэнд холбогдох хууль журмын дагуу хариуг өгнө;

2.5.2. Гадаад эмчилгээний зардалд санхүүгийн дэмжлэг хүсэж, санхүүжилт олгох журамд заасан материалыг бүрдүүлж ирүүлсэн иргэний материалын хуудасны тоо, бүрдэл хэсгийн тэмдэглэл бүхий жагсаалтыг санхүүжилтийн тооцоолол хариуцсан нарийн бичигт хүлээлгэн өгнө;

2.5.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнд хурлын зар болон хурлаар хэлэлцүүлэх иргэдийн нэгдсэн мэдээллийг тараана;

2.5.4. Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлж байгаа өвчлөл, эмчилгээнд хамрагдсан иргэдийн мэдээлэл болон эрүүл мэндийн байгууллагуудаас гаргасан эх орондоо эмчилдэг болоход чиглэсэн судалгаа, санал санаачлагыг дэмжин Эрүүл мэндийн яамны удирдлага, холбогдох газар, хэлтэст уламжлах, мэдээллээр хангана.

2.6. Гадаад эмчилгээний санхүүжилтийн тооцоолол хариуцсан нарийн бичиг:

2.6.1. Гадаад эмчилгээний зардалд санхүүгийн дэмжлэг хүссэн иргэдийн төлбөр төлсөн баримтад тулгуурлан холбогдох санхүүжилт олгох журмын дагуу тооцооллыг гарган нэгтгэн Эрүүл мэндийн яамны Эдийн засаг санхүүгийн хэлтсийн даргаар хянуулж, зөвлөлийн хуралд танилцуулна;

2.6.2. Зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу иргэдэд мөнгийг шилжүүлэх бэлтгэл ажлыг ханган холбогдох журмын дагуу шуурхай шийдвэрлүүлнэ;

2.6.3. Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн иргэдийн материалыг архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгнө;

2.6.4. Зөвлөлийн даргад гадаад эмчилгээний санхүүжилтийн талаар, санал гаргах, мэдээллээр хангана.

Гурав. Зөвлөлийн бүрэлдэхүүний эрх

3.1. Хил орчмын ард иргэд байгалийн гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан эмнэлгийн тусламж, үйлчилгээг гадаад улсад авч, санхүүгийн дэмжлэг хүссэн тохиолдолд нөхцөл бйадлыг тодруулан, зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх;

3.2. Шаардлагатай тохиолдолд иргэний гадаад улсад хийгдсэн оношилгоо, эмчилгээний талаар тодруулга материалыг иргэнээс гаргуулах;

Дөрөв. Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд эмнэлгийн дүгнэлт гаргах үйл ажиллагаа

4.1. Улсын нэг, хоёр, гуравдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төвд гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх дүгнэлт гаргах орон тооны бус дэд комисс (цаашид “Комисс” гэх) ажиллана.

4.2. Комиссыг тухайн эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ эрхэлсэн захирал ахлан, төв, тасгийн эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй байгуулна.

4.3. Комиссын ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Комиссын хурал нь комиссын бүрэлдэхүүний 90 хувиас дээш ирцийг бүрдүүлсэн тохиолдолд эмнэлгийн эмч нарын зөвлөгөөний дүгнэлтийг хүчинтэйд тооцох ба комиссын гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд ирэх боломжгүй тохиолдолд ажил, үүргийг нь орлон гүйцэтгэж байгаа албан тушаалтан хуралд оролцоно.

4.4. Дүгнэлт гаргах эрх бүхий комисс нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалт”-д орсон өвчин болохыг нотлон дүгнэлт гаргах үйл ажиллагаанд эмчлэгч эмч, шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг татан оролцуулж болно.

4.5. Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэнд эмнэлгийн дүгнэлтийг гаргахдаа төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэгийн бичлэг, онош, түүнийг баталгаажуулсан лабораторийн шинжилгээний болон дүрс оношилгооны хариуг үндэслэн хэлэлцэж, хамтын удирдлагаар шийдвэрлэнэ.

4.6. Комисс нь тус тушаалын хавсралтаар батлагдсан дүгнэлтийн маягтыг бүрэн бөглөж, эмч нарын комиссын зөвлөгөөнөөр тогтоосон өвчний заалтыг тодорхой тусгасан шийдвэрийн маягт дээр зөвлөгөөнд орсон эмч нар гарын үсгээ зурж баталгаажуулж, хурлын тэмдэглэл хөтлөн комиссын даргаар баталгаажуулна.

4.7. Комиссын дүгнэлт, хурлын шийдвэрийн хуулбарын хамт хүчин төгөлдөр гэж үзнэ.

4.8. Комисс нь дүгнэлт гаргасан иргэдийн овог нэр, өвчний оношийн талаар хагас жилийн тайланг Эрүүл мэндийн сайдын дэргэдэх гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлаар санал гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлд хүргүүлнэ.

4.9. Дүгнэлт гаргасан комиссын дарга иргэний гадаад улсад эмчилгээ хийлгэсэн эмнэлгийн дүгнэлтийг үндэслэн тус тушаалаар батлагдсан зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний онош, эмчилгээний заалтаар эмчлүүлсэн эсэхийг нягтлан баталгаажуулна.

4.10. Иргэн өөрийн хүсэлтээр гадаад улсад эмчлүүлэхээр гаргасан хүсэлт энэ журамд хамаарагдахгүй.

Тав. Хүлээлгэх хариуцлага

5.1. Холбогдох хууль, тогтоомж, энэ журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн албан тушаалтанд дараах хариуцлагыг ногдуулна.

5.1.1. Энэ журмын 2 дахь хэсгийн 2.1, 2.3-т заасан хэм хэмжээг зөрчин хувийн ашиг сонирхолд автан иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг эс шийдвэрлэсэн, 2.2-т заасан баримт бичиг нь бүрдээгүй иргэний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж гадаад эмчилгээний зардал олгохыг завдсан бол сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

5.1.2. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, энэ журмаар тогтоосон хэм хэмжээг илт хууль бусаар зөрчсөний улмаас байгууллага, иргэнд хохирол учруулсан гэм буруу нь эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол уг албан тушаалтныг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулна.

Зургаа. Бусад

6.1. "Гадаад улсад зайлшгүй шаардлагаар эмчлүүлэх өвчний жагсаалт"-д ороогүй өвчин, эмгэгтэй иргэнд гадаад эмчилгээний зардалд санхүүгийн дэмжлэг олгох асуудлаар эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргах, зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг өгөхийг хориглоно.

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 09 сарын 21-ны өдрийн
А/370 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт



**ГАДААД ОРОНД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГААР ЭМЧЛҮҮЛЭХ
ИРГЭДЭД ЭМНЭЛГИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ МАЯГТ**

.....онсар.....өдөр

Эмнэлгийн байгууллагын нэр

Өвчтөний овог _____ Эцэг эхийн нэр: _____

Нэр: _____

Төрсөн он ____ сар ____ өдөр: ____

Нас ____

Хүйс ____

Регистрийн дугаар _____

Мэргэжил _____

Ажлын газар/ сургууль _____

Хаяг _____

Утас _____

Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар _____

БОДИТ ҮЗЛЭГ:

Өндөр _____ Жин _____

Цусны даралт _____ Судасны цохилт _____

Одоогийн өвчний түүх

.....
.....
.....
.....

Шинжилгээнүүд

.....

